
**УЛААНБААТАР ХОТЫН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ЭРҮҮЛ
МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ УСТГАХ ҮЙЛДВЭР”-ИЙН 2025 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН**

/5554861/

2025 ОН

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН АГУУЛГА	ХУУДАСНЫ ДУГААР
1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	3
1.2 Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	3
1.3 Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	3
1.4 Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг	3
1.5 Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	3
1.6 Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	3
1.7 Төслийн нэр	3
1.8 Төслийн харьяаллын байршил	3
1.9 Төслийн ангилал	3
1.10 Төсөл эхэлсэн огноо	3
1.11 Төсөл хэрэгжих хугацаа	3
1.12 Үйлдвэрийг хүлээж авсан улсын комиссын дүгнэлт	4
1.13 ТЭЗҮ баталсан огноо	4
1.14 Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	4
1.15 Төслийн товч тодорхойлолт	4
2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	5
2.1 Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө	5
2.2 Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө	5
2.3 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө	6
2.4 Осол, эрсдэлийн менежментийн арга хэмжээний төлөвлөгөө	6
2.5 Хог хаягдлын менежментийн арга хэмжээний төлөвлөгөө	6
2.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	7
2.6.1 Агаарын чанарын хяналт шинжилгээ	7
2.6.2 Хөрсөн орчны хяналт шинжилгээ	7
2.6.3 Усан орчны хяналт шинжилгээ	8
2.7 Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө	8

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	9
3.1 Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө	9
3.2 Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	17
3.3 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө	21
3.4 Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө	23
3.5 Осол, эрсдэлийн менежментийн арга хэмжээний төлөвлөгөө	25
3.6 Хог хаягдлын менежментийн арга хэмжээний төлөвлөгөө	28
3.7 Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө	37
ТӨСВИЙН МЭДЭЭЛЭЛ	38
ТАЙЛАНГИЙН ҮР ДҮН	41

НЭГ.УЛААНБААТАР ХОТЫН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ УСТГАХ ҮЙЛДВЭР”-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1	1. Төсөл хэрэгжүүлэгч аж нэгжийн нэр ахуйн	“Элемент медикал” ХХК
	2. Аж ахуйн нэгжийн бүртгэлийн дугаар улсын	9011327098
	3. Аж ахуйн нэгжийн ажиллагааны чиглэл үйл	Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг хүлээн авах, тээвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах, шатаах, бутлах, ландфиллдэх
	4. Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг	СХД-ийн 36-р хороо Толгойт /18105/, 6-р хэсэг гудамж 69 тоот
	5. Захирлын нэр, утас, шуудангийн хаяг цахим	Ерөнхий захирал Б.Пүрэвсүрэн Утас:99099944 Цахим хаяг: elementmedical44@gmail.com
	6. Холбогдох мэргэжилтний утас, цахим шуудангийн хаяг нэр,	Гүйцэтгэх захирал О.Дорж Утас: 88057656 Цахим хаяг: elementmedical44@gmail.com БО-ны асуудал хариуцсан ажлтан И. Отгончимэг Утас: 99052742 Цахим хаяг: elementmedical44@gmail.com
	7. Төслийн нэр	Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал устгах үйлдвэр
	8. Төслийн харьяаллын байршил	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг 36-р хороо
	9. Төслийн ангилал	Жижиг дунд үйлдвэр
	10. Төсөл эхэлсэн огноо	
	11. Төсөл хэрэгжих хугацаа	Хугацаагүй
	12. Үйлдвэрийг хүлээж авсан улсын комиссын дүгнэлт	2013 оны 7-р сарын 20-нд барилга байгууламжийг ашиглалтанд оруулах Улсын комиссын болон техникийн комиссын акт гарсан.
	13. ТЭЗҮ баталсан огноо	2008
	14. Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	1353,6 ЭМБ-ын аюултай хог хаягдал хүлээн авч аюулгүй болгон устгасан.

1.15 Төслийн товч тодорхойлолт

Хог хаягдал устгах үйлдвэрийн төсөл нь Улаанбаатар хотын хог хаягдлын хэмжээг бууруулж, орчин үеийн техник технологийг ашиглан боловсруулалтанд оруулснаар байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндсэн түүхий эдийг бэлтгэж хог хаягдлыг эдийн засгийн үр өгөөжтэйгээр ашиглах үндсэн зорилготой.

Тус үйлдвэр нь эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал устгах болон хуванцар сав баглаа боодол үйлдвэрлэл, ханган нийлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг Улаанбаатар хотод байрлаж буй ЭМБ-уудаас цуглуулж, Монгол Улсын Хог Хаягдлын тухай хууль болон Эрүүл мэндийн сайдын 2025 оны 5 сарын 01 өдрийн А/173 дугаар тушаал 2025 оны 05 сарын 09 өдрийн А/193 тоот тушаалуудад заасан зааврын дагуу хүлээн авах, тээвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах, шатаах, устгах үйл ажиллагааг Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас олгосон газарт явуулж байна.

Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал устгах үйлдвэрийн хүчин чадал нь 3200тн/жил юм.

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“ЭЛЕМЕНТ МЕДИКАЛ” ХХК нь хүний Эрүүл мэнд болон Байгаль орчинд хор нөлөөгүй олонхын баримтлан ашиглаж байгаа зөвшөөрөгдсөн арга технологийг МУ-ын Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчны холбогдох хуулиудад нийцүүлэн Монгол Улсын үндсэн хуулийн заалт болох Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах нөхцөлийг хангахад бидний гол зорилт оршино. Үүний дагуу 2025 онд дараах 7 чиглэлээр төлөвлөж ажилласан. Энэ жилийн БОМТ-ний нийт зардал **229,556,590** төгрөг зарцуулсан.

1. Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө
2. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө
3. Осол, эрсдэлийн менежментийн арга хэмжээний төлөвлөгөө
4. Хог хаягдлын менежментийн арга хэмжээний төлөвлөгөө
5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
6. Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө
7. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө

2.1 Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тодорхойлоход төслийн явцад усны нөөц, горим, газрын гадарга, газрын хэвлий, хөрс, ургамал, агаар орчин бохирдох зэрэгт сөргөөр нөлөөлөх магадлалтай тул төслийн сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

1. Байгууллагын эдэлбэр газарт олон наст ногоон ургамал тарих, цэцэгжүүлэх, зам талбайг янзлах, орчны тохижилтыг сайжруулах
2. Халдваргүйжүүлсэн хог хаягдлын овор хэмжээг багасгах, байгаль орчинд ээлтэй байдлаар боловсруулж устгах
3. Ариутгал, халдваргүйтгэлийн чанарыг сайжруулах, тоног төхөөрөмжийг шинэчлэх

2.2 Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө

Төслийг хэрэгжүүлэх явцдаа үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаагийн хувьд БОНБНУ-ний тайланд тусгагдсан зөвлөмжийг баримтлан ажиллах. Мөн компанийн удирдлагын тушаалаар байгаль орчны асуудал хариуцсан ажилтныг томилж буюу тухайн асуудлыг хэн нэгэн албан тушаалтанд хариуцуулж эзэнтэй болгох. Ингэснээр уг ажилтан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн

хэрэгжилтийн асуудлаар компанийн захиргаа болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын өмнө хүлээх хариуцлагын орчин бүрдэнэ.

2.3 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө

“Элемент-Медикал” ХХК нь “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал цуглуулах, устгах үйлдвэр” төслийг хэрэгжүүлэхдээ, байгаль орчны экологийн горимыг аль болох алдагдуулахгүй байх, нөхөн сэргээх ажлыг зохих түвшинд чанартай гүйцэтгэж, төслийн сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээний талаар БОНБНУ-ний тайланд тусгагдсан зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, мөн төслийн үйл ажиллагаандаа Монгол улсын холбогдох хууль, эрх зүйн баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажиллах зорилт тавьж ажиллаж байгаа болно.

2.4 Осол, эрсдэлийн менежментийн арга хэмжээний төлөвлөгөө

Төсөл хэрэгжих талбайн орчим үүсч болох байгалийн, хүний үйл ажиллагааны гаралтай аюулт үзэгдлийн талаар Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд дэлгэрэнгүй тусгасан бөгөөд эдгээр аюулт үзэгдэл үүсэх шалтгаан, давтамж, үр дагавраас урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах арга хэмжээний талаар мөн тайлангийн 6-7 дугаар бүлэгт тусгагдсан. Үнэлгээний явцад байгалийн, хүний үйл ажиллагааны гаралтай аюулт үзэгдэл болон тус төслийн үйл ажиллагаатай холбоотой үүсэх эрсдэлийн түвшинг үнэлсэн бөгөөд эрсдэлийн үнэлгээнээс үзэхэд төслийн үйл ажиллагаанаас хамгийн их эрсдэл үүсгэх хүчин зүйл бол хөдөлмөр хамгаалах, техникийн аюулгүй байдал алдагдахтай холбоотой болох нь харагдаж байна. Үүнтэй холбогдуулан осол, эрсдэлийн менежментийн чиглэлээр хийх арга хэмжээг 3-р бүлэгт дэлгэрэнгүй дурдсан болно.

2.5 Хог хаягдлын менежментийн арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг нарийвчлан тодорхойлсны үндсэн дээр гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээхэд чиглэсэн БОНБНУ-ний тайлан дээр тусгагдсан 7 чиглэлийн үйл ажиллагааны зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах. Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хууль эрхзүйн бүлэгт орсон хууль, дүрэм журам, стандарт болон Олон улсын конвенцийн холбогдох заалтыг мөрдлөг болгон ажиллах шаардлагатай. Ингэснээр төслөөс бий болох эрсдэл, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

2.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр /ОХШХ/ нь байгаль орчин, нийгэм эдийн засгийн үнэт зүйлийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа нь ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичиг болно. ОХШХ-ийг жил бүр шинэчлэн боловсруулж, хяналт шинжилгээний дээж, сорьцыг МУ-ын болон гадаадын итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан аргазүй, стандартын дагуу шинжлүүлэх тухайн оны эхэнд БОАЖЯ-аар батлуулж, оны эцэст тэдгээрийн биелэлтийг мөн тайлагнана. Төслийн байгаль орчны нөлөөллийг тогтоохын тулд дараах хоёр бүсэд ОХШХ-ийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Нөлөөллийн цөм бүс
2. Нөлөөлөлд өртөгч бүс

Нөлөөллийн цөм бүс нь тухайн төслийн хэрэгжилт, хамрах талбайн хил заагаар хязгаарлагдана. Энэ хэсэгт ОХШХ-т туссан байгалийн объект бүрээс дээж авах ба нөлөөлөлд өртөгч бүс нь хамрагдах газрын заагаас гадагш бүх зүгт жигд тархалттай байх тул тус төслийн хувьд хамгийн ихдээ 1 км байхаар тооцлоо. Энэ бүсэд ОХШХ-т туссан байгалийн объект бүрээс дээж авах шаардлагагүй ба тухайн төслийн онцлог, байгаль цаг уурын нөхцөлөөс хамаарч 1 болон түүнээс олон тооны хяналтын цэг тогтоогдох боломжтой. Хяналтын цэгүүдийг сонгохдоо тухайн байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн онцлог, шилжилт хөдөлгөөн, төслийн нөлөөлөл, эрчим зэрэг хүчин зүйлийг харгалзана. ОХШХ-ийг хэрэгжүүлэхдээ хяналтын цэгүүдэд заагдсан хугацаанд мэргэжлийн байгууллагаар хийлгэх ба хяналтын цэгүүдийн байршлыг өөрчлөх боломжтой.

2.6.1 Агаарын чанарын хяналт шинжилгээ

Шинжилгээний байршил: Төслийн талбайд Хяналтын хугацаа, давтамж: Хагас жилд 4 удаа

Хэрэглэгдэх тоног төхөөрөмж: Улсын эсвэл мэргэжлийн байгууллагын итгэмжлэгдсэн лаборатори Баримтлах стандарт, аргачлал:

-MNS 5885:2008-Агаар бохирдуулах органик биш бодисын хүлцэх хэм хэмжээ

-MNS 4585:2007-Гадаад орчны агаарын түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж

2.6.2 Хөрсөн орчны хяналт шинжилгээ

Шинжилгээний байршил: Төслийн талбайд

Хяналтын хугацаа, давтамж: Намар 9-р сарын 15±5 хоног

Хэрэглэгдэх тоног төхөөрөмж: Улсын эсвэл мэргэжлийн байгууллагын итгэмжлэгдсэн лаборатори Баримтлах стандарт, аргачлал:

-MNS 3298-1990 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага

MNS 5850-2019 - Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ

2.6.3 Усан орчны хяналт шинжилгээ

Шинжилгээний байршил: Төслийн талбайд

Хяналтын хугацаа, давтамж: Намар 9-р сарын 15±5 хоног

Хэрэглэгдэх тоног төхөөрөмж: Улсын эсвэл мэргэжлийн байгууллагын итгэмжлэгдсэн лаборатори Баримтлах стандарт, аргачлал:

-MNS ISO 5667-1-2002 Усны чанар. Дээж авах, 1-р хэсэг. Дээж авах хөтөлбөр боловсруулах заавар

2.7 Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө

Оролцогч талууд:

- БОАЖЯам
- НБОГ
- Орон нутгийн захиргаа ба ИТХ
- Нөлөөллийн бүс дэх оршин суугчид ба ажилчид


Тайлагнах шаардлага: Тус төслийн хүрээнд оролцогч талуудад бодит мэдээллийг хүргэх, БОАЖС-ын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах тухай журмыг хэрэгжүүлэх, оролцогч талуудын саналыг байгаль хамгаалах үйл ажиллагаандаа тусгах

№	Оролцогч талууд	Хэлбэр	Агуулга	Хугацаа	Санал авах чиглэл	Зохион байгуулах газар
1	БОАЖЯ	Тайлан	БОМТ	11 сарын 25 12 сарын 25	БОМТ	БОАЖЯ
2	НБОГ	Тайлан				НБОГ
3	Орон нутгийн захиргаа болон ИТХ	Тайлан Уулзалт				Захиргааны байр
4	Нөлөөллийн бүс дэх оршин суугчдад	Тайлан Уулзалт				Төсөл хэрэгжүүлэгчийн байр

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт	Төсөв /төгрөг/
3.1 Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө			
.1.	1. Үйлдвэрийн орчны ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх	<p>1. Үйл ажиллагааны явцад үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчныг хамгаалах зорилгоор хамт олноороо байгууллагын эзэмшлийн 400м² талбайд 100 ширхэг модны арчилгааг хийж, зам талбайг цэвэрлэн шинээр 15 ширхэг улиас, нарс-15, хайлаас суулгах ажлыг хийж гүйцэтгэлээ.</p> <p style="text-align: center;">Улиас, хайлаас, нарс суулгасан байдал</p> <div data-bbox="525 711 997 1404"></div> <div data-bbox="1029 711 1381 1058"></div> <div data-bbox="1402 695 1785 1052"></div> <div data-bbox="1029 1079 1801 1435"></div>	

2. Манай үйлдвэрийн байршил дахь хөрсний онцлог нь шим тэжээл багатай тул ногоон байгууламж төлөвлөсөн хэсэгт хөрсийг баяжуулан үржил шимт хөрс худалдан авч тарьсан мод бутны эргэн тойронд дэвсэж, мандлын цэцэгийн үр үрслүүлэн суулга сан.



3. Үйдвэрийн гадна талбайн хөрсний элэгдэл эвдрэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Үйдвэрийн гадна талбай буюу хашаан доторх хөрсний элэгдэл эвдрэлээс урьдчилан сэргийлэн машин явах хэсгийн талбайг бетонжуулсан бөгөөд зогсоолын хэсгийг хайрга асгаж байгалийн ус хөрсөнд шигээх байдлаар шийдсэн.



Үйлдвэрийн гадна болон дотоод орчны тэмдэг сайжруулах нэмэгдүүлэх ажил хийгдсэн.





Цугларах цэг



Тамхи татах цэг



Авто зогсоолын тэмдэглэгээ



Цугларах цэгийн ойр орчинд түр зогсох
хориотой тэмдэг байрлуулсан

“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан 2025 он



	<p>5. Тээвэрлэлтийн тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл</p>	<p>Тээвэрлэлтийн шугамд нэмэлтээр нэг тээврийн хэрэгсэл нэмэлтээр оруулсан. Авто замын ачаалал, эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх иргэдийн тоо нэмэгдсэн, төрөөс хэрэгжүүлж буй эрт илрүүлгийн шинжилгээ оношилгооны үйл ажиллагаа, ковидын дараах өвчлөл ихсэлт зэрэг хүчин зүйлээс хамааран эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал нэмэгдсэнтэй холбоотойгоор тээвэрлэлтэнд 1,5 тн даацтай машин нэмэж тээвэрлэлтийн шугаманд оруулсан.</p> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div>	
<p>3.1.2</p>	<p>Үйл ажиллагаа явуулж буй хорооны засаг захиргааны удирдлагуудтай хамтран эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагааг хамтран зохион байгуулсан</p>	<p>Энэ онд багтаан үйл ажиллагаа явуулж буй хорооны удирдлагуудтай болон өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран тус хорооны айл, өрхүүдээс үүсэх эмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх явцад үүсэх аюултай хог хаягдлыг үнэ төлбөргүй хүлээн авах цэг байгуулахаар төлөвлөсөн болно.</p> <ul style="list-style-type: none"> • Тус цэгийг байгуулах явцад гарах зардлыг байгууллагын төсвөөс гаргахаар тусгасан болно. • Тус цэгийг ашиглаж эхэлнээр эзэнгүй хаягдах аюултай хог хаягдлын тоо хэмжээ багасах давуу тал үүснэ. <p>Мөн СХД-н 26 хорооны өрхийн эмнэлгээс эмч мэргэжилтнүүдийг урьж ажилчиддаа эрүүл мэндийн зөвөлгөө сургалт мэдээллийг авч дараах таван хавдрын илрүүлэгт ажилчдаа хамруулсан.</p>	



Тухайн үзлэгээр дараах таван чиглэлийн хавдрын эрт илрүүлгийн тандалт үзлэг хийгдсэн.

- Умайн хүзүүний хавдрын илрүүлэг
- Хөхний хавдрын илрүүлэг
- Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг
- Ходоодны хавдрын эрт илрүүлэг
- Түүрүү булчирхайн хавдрын эрт илрүүлэгийн үзлэгт хамрагдаж асуумж бөглүүлсэн:.

Мөн тухайн өвчлөлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх, ямар тохиолдолд эмнэгэ болон эрүүл мэндийнбайгууллагад хандах, эрт илрүүлэг хэрхэн эрүүл мэндэд сайнаар нөлөөлөх тухай болон бусад халдвараас гэр бүл ойр дотны хүмүүсээ хамгаалах тухай мэдээлэл агуулсан сургалт орсон.



Мөн Сонгинохайрхан дүүргийн 26 хорооны ӨЭМТ-өөр дамжуулан дүүргийн хэмжээнд ажиллаж байгаа ӨЭМТ-үүдийн сонгогдсон нэг ажилтнуудад “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент, түүнийг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, хог хаягдал түр хагалах цэгт тавигдах шаардлага гэж мэт агуулага багтаасан сургалт явуулсан.

3.2 Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

3.2.1 БО-ны хяналт шинжилгээг /агаар, хөрс, гүний худгийн ус, хаягдал ус, утаа/-нд тогтоосон цэгүүдээс хийлгэж дүгнүүлэх

Байгаль орчин хэмжилзүйн төв лаборатори, Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газар болон Усны газар, геологийн судалгаа шинжилгээний төвтэй хамтран ажиллаж байна. Үйлдвэрийн гадаад орчин, шатаах зуухны орчин болон ландфиллын талбайн орчны 3 цэгт агаар, хөрсний чанарын шинжилгээ, гүний худагт усны цахилгаан дамжуулах чанар, хатуулаг, эрдэсжилтийн шинжилгээг байгаль орчин хэмжилзүйн төв лабораториор жилд 2 удаа хийлгэн хянан дүгнүүлсэн. Мөн үйлдвэрийн цэвэрлэгээ, үйлчилгээнээс гарах хаягдал усанд улиралд 1 удаа буюу жилд 4 удаа усны газрын төв лабораториор, шатаах зуухны яндангаар гарах утаанд жилд 1 удаа, шатаах зуухны үнснээс дээж авч улиралд нэг удаа буюу 4 удаа шинжилгээ хийлгэсэн болно. Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газраар тус тус шинжилгээ хийлгэж дүгнүүлэхээр төлөвлөн хүсэлт гаргасан байна. /2025 онд улиралд өгсөн орчны хяналт, шинжилгээний дүн болон шатаах зуухны үнснээс авсан шинжилгээ, хаягдал усны шинжилгээний хариу хавсаргав/

Хөрсний шинжилгээ /2025 он/

№	Үзүүлэлтүүд	2025 оны 10-р сарын 02		Зөвшөөрөгдөх стандарт хэмжээ
		Ланд/талбай	Оффис/орчим	
1.	Cd	0.13	0.24	3
2	Pb	17.69	22.26	100
3	Hg			2
4	Cr	88.28	38.79	150
5	Zn	103	535 67.87 12.10нд	300
6	Cu	34	22.87	100
7	Sr	167	169 12.10нд	150

Усны шинжилгээ 2025 он /гүний худаг/

№	Үзүүлэлтүүд	2025 оны 12-р сарын 04	Зөвшөөрөгдөх стандарт хэмжээ
1	pH	7.65	6.5-8.5
2	EC $\mu\text{S}/\text{cm}$		1000
3	Ca мг/л	70.54	100
4	Mg мг/л	6.81	30
5	Na+K мг/л	15.87	200

**“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан 2025 он**

6	SO ₄ мг/л	39.63	500
7	Cl мг/л	15.60	350
8	HCO ₃	195.20	-
9	Эрд мг/л		-
10	Хат мг-экв/л	4.08	7.0
ЕС-Цахилгаан дамжуулах чанар, хатуулаг, эрдэсжилт			
1	Ж.б мг/л		-
2	ПИЧ мг/л		-
3	NH ₄ мг/л	0.03	1.5
4	NO ₂ мг/л	0	1.0
5	NO ₃ мг/л	18.90	50
6	PO ₄		3.5
7	F мг/л		0.7-1.5
8	Fe мг/л	0	0.3
Ж.б – Жинлэгдэх бодис, ПИЧ-Перманганатын исэлдэх чанар			

Шатаах зуухны үнсний шинжилгээ /2025 он/

Үзүүлэлт	Li	Be	Sc	Cr*	Co	Ni	Dy
2025 оны 06-р сарын 09							
Үр дүн	13.04	0.05	1.83	354	7.08	309	0.59
Аттестатчилсан утга	43.50	9.95	11.51	-	32.42	34.90	6.39

Үзүүлэлт	Rb	Y*	Mo	Cd	Sb	Cs	Ho
2025 оны 06-р сарын 09							
Үр дүн	8.25	1.23	3.67	0.5	85.57	0.18	0.14
Аттестатчилсан утга	84.75	38.64	20.21	0.60	-	16.60	1.24

Үзүүлэлт	La	Ce	Pr	Nd	Eu	Ti	Tb
2025 оны 06-р сарын 09							
Үр дүн	2.39	4.24	0.26	2.65	1.66	0.5	
Аттестатчилсан утга	43.69	89.88	9.82	32.82	1.40	2.32	

Хаягдал усны шинжилгээ /2025 он/

Үзүүлэлт	Cr	Al	Mn	Co	Ni	Be	Cu
2025 оны 10-р сарын 22							
Үр дүн	0.01	0.5	-	0.005	0.0203	0.005	0.03

*“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан 2025 он*

ЗДХ	1	0.24	0.03	0.1	0.5	-	1
Үзүүлэлт	Zn	Ta	B	V	Ga	In	Cd
2025 оны 10-р сарын 22							
Үр дүн	0.06		0.0101	0.0564	0.005		0.005
ЗДХ	5		-	-	-		0.05
Үзүүлэлт	Sr	Ba	Pb	Li	Fe	Ag	No ₃
2025 оны 10-р сарын 22							
Үр дүн	0.16	0.0163	0.005	0.0056	0.5117	0.0018	0.29
ЗДХ	-	-	0.02	-	3	-	-

Шатаах зуухны хоёр дамжлагат шүүлтүүрийг бүрэн сольж ажилласан.

*“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан 2025 он*



3.3 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

3.3.1

“Ландфиллийн талбай”-н зориулалтаар шинээр олгосон газарт ариутгасан хог хаягдал болон хог хаягдлын шатаалтаас үүссэн үнсний хаягдал нь булагдаж байгаа. Жил тутамд ашиглагдсан ландфиллийн талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийдэг болно. 2024 онд мөн тус талбайн эргэн тойрны задгай хог хаягдлыг цэвэрлэн техникийн нөхөн сэргээлт хийсэн.




2025 оны 05 сарын 08-ны өдөр 13 цагийн үед Байгууллагын эзэмшлийн 1700 м² болон байгууллагын гаднах орчны 250м радиус доторх нийтийн эзэмшлийн зам талбай, явган хүний замын хог хаягдал, гуу жалганы хог хаягдлыг ажилчид дөрвөн багт хуваагдан цэвэрлэгээг хийж гүйцэтгэн нийт 3,5 тонн хогийг хогийн цэгт хүргэсэн.





“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан 2025 он

.3.4 Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө

<p>3.4.1</p>	<p>Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж жил бүр батлуулж байх</p>		<p>Үйл ажиллагаанаас байгаль орчинд үүсэж болох сөрөг нөлөөллийг бууруулах арилгах, байгаль орчныг хамгаалах чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулан ажилласан.</p>	<p>-</p>
		<p>“Байгальд ээлтэй хог хаягдлын менежмент” сэдэвтэй сургалтыг 2023/09/18-2023/09/20 өдрүүдэд нисэх буудлын захиргааны байрны 2 давхарт зохион байгуулсан. Сургалтанд НУБИЭ-н барилга байгууламжид үйл ажиллагаа эрхлэгч болон түрээслэгч байгууллагуудын ажилтнууд хамрагдсан. Сургалтын ирц 3 өдөр нийлээд Сургалтын агуулга нь:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Хог хаягдлын хор нөлөө ➤ Хог хаягдлыг хэрхэн багасгах вэ? ➤ Хог хаягдлын ангилал, тэмдэг тэмдэглэгээ ➤ Дахивар нөөц түүний ангилал, ялгаа ➤ Монгол улсын хэмжээнд дахин боловсруулах үйлдвэрийн тоо хэмжээ болон үйл ажиллагааны чиглэл товч танилцуулга гэсэн мэдээллийг багтаасан. Сургалтын дараа дахивар нөөцийг хог хаягдлаас нь ялгах дадлага ажил хийж тухай бүрд нь хог хаягдлын тухай мэдлэг ойлголтын зөрүүг нь гаргаж тайлбарлаж өгсөн. 		

Хог хаягдлыг эх үүсвэрээр нь дараах байдлаар ангилна.



Хатуу хог хаягдал
(Municipal Solid Waste)



Эмнэлгийн хог хаягдал
(Medical Waste)



ХАА
(Agricultural Waste)



Үйлдвэрийн хог
(Industrial Waste)



Барилгын хог
(Construction & Demolition Waste)



Аюултай хог
(Hazardous Waste)



Уул уурхайн хог
(Mining Waste)



Электрон хог
(E-Waste)

Сургалтын дараа дахивар нөөцийг хог хаягдлаас нь ялгах дадлага ажил хийж тухай бүрд нь хог хаягдлын тухай мэдлэг ойлголтын зөрүүг нь гаргаж тайлбарлаж өгсөн нь сургалтын үр дүнг нэмэгдүүлсэн. Ажилчид зөвхөн албан байгууллага дээрээ биш ар гэртээ бас хог хаягдлаа ангилан дахивар нөөцөө нэгтгэн дахивар нөөц авах цэгт хүргэдэг болсон.



3.5.2	Мэдлэг, чадварыг дээшлүүлэх /сургалт	<p>Мэргэжлийн байгууллагаас өгсөн заавар, зөвлөмжийн дагуу ажилчдын дунд тогтмол дадлага, сургуулилт явуулж боловсон хүчнийг бэлтгэн ажиллаж байна.</p> <p>Мөн жилд 1-2 удаа мэргэжлийн байгууллагын сургагч багш нараас сургалт авч, ажилчидаа дадлагажуулан ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none">✓ Халдвар хамгааллын✓ Санхүү, аж ахуйн✓ Техник, тоног төхөөрөжийн тасгууд хамтран жилийн сургалтын төлөвлөгөөг боловсруулан ажилчдын дунд тогтмол сургалт зохион байгуулан ажиллаж байна. <p>Сургалтанд хамрагдаж буй байдал</p>	
		 <p>Зураг 1. СХД-ийн онцгой байдлын газраас авсан сургалт/</p>	

*“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан 2025 он*



3.6 Хог хаягдлын менежментийн арга хэмжээний төлөвлөгөө, хамтын ажиллагаа

3.6.1 БОННУ-д тусгасны дагуу үйл ажиллагааны зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах;
Хог хаягдлын тухай хууль болон Аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, бүртгэх, тайлагнах журмын шаардлагыг хэрэгжүүлэх

Хог хаягдлын мэдээ, тайланг сар, улирал, хагас жил, жилийн эцсээр нь нэгтгэн гаргаж НЭМГ, НЗАА-ны хариуцсан мэргэжилтнүүдэд цаг тухай бүрт нь илгээж ажилласан.

1. Анагаахын Шинжлэх Ухааны Их Сургуултай тус сургуулийн салбар Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн Эрүүл ахуйч тархвар судлаач мэргэжилээр сураглцагч оюутнуудад эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын ангилал устгал, анхан шатны бүртгэл мэдээлэл гэх мэт сэдвийн хүрээнд АШУИС-ийн нийт 102 оюутанд “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент, үйлдвэрийн тухай танилцуулга” сургалт 4 удаа зохион байгуулсан.
2. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал нь үүсэн цэг дээрээ буруу ангилах зориулалтын саб баглаа боодол ашиглахгүй байх нь устгах үйл ажиллагаанд хэрхэн хүндрэл учруулдаг талаар эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал хариуцсан ажилтнуудад мэдээлэл өгдөг.



3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд “Монголлын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо”-той хамтарж ажилласан ба холбоогоор дамжуулан хаягдал дахин боловсруулах үйлвэрүүдтэй танилцаж хамтран ажилласан. Үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарсан хог хаягдлаа дахин ашиглах, дахин боловсруулах гэх мэт үйл ажиллагаа явуулдаг байгууллагад нийлүүлэн ажилласан. Дахин боловсруулалтын менежментийг хэрэгжүүлэгч байгууллага болж ажилласан ба байгууллагаас гарч байгаа хатуу хог хаягдалд менежмент хийж “Дахивар нөөц”-ийг цуглуулах, дахин боловсруулах үйлдвэрүүдэд дамжуулах ажлуудын хүрээнд байгууллагын хэмжээнд ангилалтай хог хаягдлын

сав байрлуулсан.



- Хуванцар хог хаягдал /зөвхөн ус ундааны сав/ дахин боловсруулалтаар Монголдоо тэргүүлэх байгууллага болох “TML” – ХХК тай хамтран ажиллах гэрээ байгуулан байгууллагаас гарч байгаа хуванцар хог хаягдал болон ажилчдынхаа ар гэрт үүссэн хуванцар хог хаягдлыг байгууллага дээр цуглуулан тухайн байгууллагад нийлүүлэн ажилласан. Ингэснээр дахин боловсруулах түүхий эдийн нөөц бүрдүүлэх мөн цаашлаад хогийн цэгийн дүүргэлтийг багасгах, хог хаягдлыг эргэлтэнд оруулах зэрэг маш олон талын үр ашигтай үйл ажиллагаа



болж чадсан. Мөн тухайн байгууллагын үйлдвэрийн байранд зочилон ус ундааны сав баглаа боодол дахин боловсруулах тоног төхөөрөмж, шат дамжлага, гарч байгаа түүхий эдийн төрөл ангилалтай танилцав.



- Техникийн үзлэг үйлчилгээнээс гарсан ашигласан тос дахин боловсруулан М-100 маркын “Мазут” үйлдвэрлэх “Хай Би Ойл” ХХК тай хамтран ажиллах гэрээ байгуулан тээвэрлэлтийн машин, механизмын ашигласан хаягдал тос нийлүүлэн ажиллаж байна.



- Ажилчдын гал тогооноос гарсан хаягдал шингэн тос дахин боловсруулах “Монгол саван”- ХХК, “Сайн саван” ХХК-тай зэрэг байгууллагуудад гал тогооноос гарсан хаягдал тос нийлүүлэн байгууллагад хэрэгтэй угаалга цэвэрлэгээнд ашиглах саван авч ашиглаж байна.




Гал тогооны ашигласан тос



Угаалга цэвэрлэгээнд ашиглах
эдийн саван

Нийгмийн хариуцлагын хүрээнд оролцсон үйл ажиллагаа

1. Байгууллагын “Ахмад настан”-гуудаа Ахмадын баяр тохиолдуулан хүлээн авч гарын бэлэг дурсгалын зүйл өгсөн.



ЭМБ-ын аюултай хог хаягдлын төрөл, хэмжээ, устгал

“Элемент медикал” ХХК нь ЭМС-ын 2025 оны А/173 дугаар тушаалын гуравдугаар хавсралт буюу “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг дахин боловсруулах, устгах заавар”-ын дагуу 2025 онд нийт 710 гаруй эрүүл мэндийн байгууллагуудтай гэрээ байгуулан ажилласан (Хүснэгт 1).

Гэрээт байгууллагуудын төрөл

Хүснэгт 1.

ЭМЯ-ны харъяа эмнэлэгүүд	8
ЭМГазар	30
Хувийн эмнэлэг (том)	189
ӨЭМТ болон бусад хувийн эмнэлэг	479
Бүгд	706

2025 оны 1-12 сар дуустал нийт **1353,6 тонн** ЭМБ-ын аюултай хог хаягдал татан авч хог хаягдлын ангилал бүтцээс хамааран автоклавт халдваргүйжүүлэн бутлах, шатаах, капсулдах, ландфиллдэх зэрэг аргуудыг ашиглан устгасан. Нийт хүлээн авч устгасан хог хаягдлыг Хүлээн авч устгасан хог хаягдлыг бүтцээр нь авч үзвэл:

- Халдвартай хог хаягдал – **1002,4 тн**
- Хурц үзүүр, иртэй хог хаягдал – **133,2 тн**
- Эмгэг хог хаягдал – **36,4 тн**
- Эмийн болон эсэд хортой хог хаягдал- **94,2 тн**

“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан 2025 он


Он, сар, өдөр	Хүлээн авсан хог хаягдлын хэмжээ (тонноор)					Устгасан хогны хэмжээ (тонноор)		
	Халдвартай	Хурц үзүүр ирмэгтэй	Эмгэг	Эмийн болон эсэд хортой	Бусад шатаах хог хаягдал	Халдваргүйжүүлж булсан	Нийт шатаасан	Нийт
I	93.4	12	2.9	2.2	8.4	107.6	11.3	118.9
II	79.5	10.6	2.8	2.2	7.7	92.4	10.6	103
III	77.6	10.5	2.8	3.4	7.8	91.5	10.7	102.2
IV	89.2	12.6	3.4	8.4	9.2	110.2	12.6	122.8
V	84.2	11.9	3	9.4	6.3	105.6	9.4	115
VI	81.2	11.3	2.9	4.7	6.9	97.2	9.8	107
VII	72.5	9.1	2.5	5.2	6.3	86.7	8.8	95.5
VIII	87.6	10.6	3.2	18.1	6.2	116.4	9.5	125.9
IX	78.6	11.3	4.1	16.6	5.8	106.6	9.9	116.5
X	93	12.1	3.6	7.7	6.5	112.8	9.9	122.7
XI	78.8	10	2.5	10.8	7.9	99.6	10.4	110
XII	86.6	11.1	2.6	5.5	8.4	103.2	10.9	114.1
Бүгд	1002.4	133.2	36.4	94.2	87.4	1229.8	123.8	1353.6

Дээрх хог хаягдлыг нэр төрөл болон боловсруулан устгасан аргаар нь ангилан авч үзвэл:

- Нийт хог хаягдлын Халдвартай - 1002,4 тн буюу 74% , Хурц үзүүр ирмэгтэй – 133,2 тн буюу 10%, Эмгэг – 36,4 тн буюу 3%, Эмийн болон эсэд хортой – 94,2 тн буюу 7%, бусад шатаах хог хаягдал – 87,4 тн буюу 6%-ийг тус тус эзэлж байна (Дүрслэл 1).


Дүрслэл 1

“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан 2025 он




- Нийт аюултай хог хаягдлыг дараах аргаар боловсруулан устгасан (Дүрслэл 2). Үүнд:
 - Халуун, өндөр даралттай уураар халдваргүйжүүлэн бутлаж, жижиглэн ландфилд булах
 - Өндөр хэмд шатааж үнсийг ландфилд булах

Дүрслэл 2 Нийт хог хаягдлыг боловсруулан устгасан арга




Хүлээн авсан нийт хог хаягдлын төрлийг сараар тооцоолоход халдвартай хог хаягдал сард дунджаар 83,5 тн (Дүрслэл 3), хурц үзүүр, ирмэгтэй хог хаягдал сард дунджаар 11,1 тн, эмгэг хог хаягдал 3 тн, бусад шатаах хог хаягдал 7,3 тн байна. Харин эмийн болон эсэд хортой эмийн хог хаягдал сард дунджаар 7,8 тн бөгөөд VIII, IX сард хамгийн их хэмжээгээр устгагдсан байна (Дүрслэл 4).

Дүрслэл 3 Халдвартай хог хаягдлын сар бүрийн тоо хэмжээ (тонноор)



Хурц үзүүр, ирмэгтэй, эмгэг, эмийн болон эсэд хортой,
 бусад шатаах хог хаягдлын сар бүрийн тоо хэмжээ (тонноор)

Дүрслэл 4



*“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан 2025 он*


Хүлээн авч боловсруулан устгасан хог хаягдлыг гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын харъяа дүүргээр ангилан дүгнэхэд:

- Халдвартай хог хаягдал 1019,1 тн буюу нийт хог хаягдлын 80,3%;
- Хурц үзүүртэй, ирмэгтэй хог хаягдал 159,6 тн буюу нийт хог хаягдлын 12,6%;
- Эмгэг хог хаягдал 90,7 тн буюу нийт хог хаягдлын 7,1%-ийг тус тус эзэлж байна.

Нийт 6 дүүрэг, 1 аймгийн харъяа эрүүл мэндийн байгууллагаас хог хаягдал хүлээн авснаас Баянгол дүүргээс хамгийн их хог хаягдалыг хүлээн авсан байна (Дүрслэл 5).

Дүүрэг, аймгийн харъяа эрүүл мэндийн байгууллагаас
хүлээн авсан хог хаягдлын тоо хэмжээ (тонноор)

Дүрслэл 5.



*“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан 2025 он*

3.7 Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө			
3.7.1	БОМТ-ний хэрэгжилтийн талаар тайлагнах	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар тус хорооны оршин суугчдын дунд тайлагнах арга хэмжээг 2025 оны 11-р сарын 19-20 ны өдрүүдэд зохион байгуулан ажиллаа. Уг арга хэмжээг нийт 20 хүний бүрэлдэхүүнтэйгээр явууллаа.	

“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан 2025 он


Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдсан төсөв

№	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны зардал	Ажилчдын Хөдөлмөрийн хөлс	Нийт зардал
I.Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний хүрээнд				
1	Байгууллагын эзэмшлийн талбай болон гаднах орчны эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх ажилд	800 000	-	800 000
2	Тээвэрлэлтэнд 1 машин шинээр авсан	24 000 000	-	24 000 000
3	Бутлах машины хүчин чадал нэмэгдүүлэх тоног төхөөрөмж шинэчилэх ажлын хүрээнд эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал бутлах машин худалдан авсан.	109 185 000	-	109 185 000
Нийт зардал		133 985 000		133 985 000
II. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн арга хэмжээний хүрээнд				
1	Байгууллагын эдэлбэр газарт олон наст ногоон ургамал тарих, цэцэгжүүлэх, зам талбайг янзлах, орчны тохижилтыг сайжруулах ажилд	7 000 000	-	7 000 000
Нийт зардал		7 000 000	-	7 000 000
III. Осол, эрсдэлийн менежментийн арга хэмжээний хүрээнд				
1	Ажилчдын хувийн хамгаалах хувцас хэрэгсэл /Нэг удаагийн хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, ажлын гутал, өмд, цамц/	14 720 000	-	14 720 000
	Галын хор болон галын булан тохижуулах, цэнэглэх нэмэж байршуулахад	3 157 800	-	3 157 800
Нийт зардал		17 877 800		17 877 800

“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан 2025 он

IV. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн арга хэмжээний хүрээнд				
1	БО-ны шинжилгээ /агаар, /	198 500*2		397 000
2	БО-ны шинжилгээ хөрс	85 800*2		171 600
3	БО-ны шинжилгээ /гүний худгийн ус/	90 000* 2		180 000
4	Шатаах зуухны үнс шинжилгээ	66 000*4		264 000
5	Хаягдал усны шинжилгээ	I улирал 576 400 II улирал 63 000 III улирал 119 340 IV улирал 105 500	-	864 240
6	Шатаах зуухны утааны шинжилгээ	350 000	-	350 000
Нийт зардал		2 226 840		2 226 840
V. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд				
1	Үйлдвэрийн тохижилт, засвар үйлчилгээнд	47 449 550	-	47 449 550
2	Ариутгал, халдваргүйтгэлийн тоног төхөөрөмжийн сэлбэг,	3 465 400		3 465 400
3	Сэлбэг хэрэгсэл /шатаах зуух/	17 552 000		17 552 000
Нийт зардал		68,466,950		68,466,950
2025 онд зарцуулсан нийт зардал				229,556,590

Нийт зардал



- Осол, эрсдэлийн менежментийн арга хэмжээний хүрээнд
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн арга хэмжээний хүрээнд
- Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын
- Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн арга хэмжээний хүрээнд
- Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд

ТАЙЛАНГИЙН ҮР ДҮН

Байгууллагын 2025 оны Байгаль Орчны Менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг 95% -тай хэрэгжүүлэн ажилласан байна.

Хэрэгжээгүй 5% нь дээрх чиглэл бүхий төлөвлөгөөний тодорхой хэсгүүд болно. Тухайлбал автомашины дулаан зогсоол нэмэгдүүлэх. Уг арга хэмжээ бүрэн хэрэгжүүлээгүй шалтгаан нь байгууллагад нэн шаардлагатай техник хэрэгсэл болон тоног төхөөрөмжийн шинэчлэлт, байгууллагын төлөвлөгөөнд тусгагдаагүй олон ажлууд хийгдсэний улмаас санхүү, эдийн засгийн хүрэлцээгүй байдлаас үүдэн хойшлогдсон болно. Эдгээр арга хэмжээнүүдийг дараа оны БОМТ-д нэмэлтээр тусган хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа болно.